



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/331

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Монгол Улсын Эрүүл мэнд, спортын яам болон Канад Улсад төвтэй "Лаурел сан" хооронд 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 6 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

081058

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Нэйл Нааяа Поннэттира Nanaya Neil Ponnettira	Канад Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001795	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017-09-11 2017-09-16 /5хоног/
2.	Макнили Патрик Дэвид Mcneely Patrick David	Канад Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001796	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017-09-11 2017-09-16 /5 хоног/
3.	Андерсон Доналд Уиллис Anderson Donald Willis	Канад Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001797	Нүүрний нөхөн сэргээх пластик мэс засал судлал	Эмчлэх	2017-09-11 2017-09-16 /5 хоног/
4.	Ахмад Шах Ашрафи Ashrafi Ahmad Shah	Канад Улс	Хавдар судлалын үндэсний төв	ГЭ0001798	Цээжний мэс засал судлал	Эмчлэх	2017-09-11 2017-09-16 /5 хоног/

Эрүүл мэндийн сайдын
 2017 оны ᠔᠘ сарын ᠒᠙ өдрийн
 А/᠑33/ дугаар тушаалын хавсралт

5.	Хью Макферсон Парсонс Parsons Hugh Macpherson	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	ГЭ0001799	Нүд судлал	Эмчлэх	2017-09-11 2017-10-01 /20хоног/
6.	Дебора Ма Mah Deborah	Канад Улс	Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	ГС0000223	Мэс заслын сувилахуй	Сувилагч	2017-09-11 2017-10-01 /20 хоног/